

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН САЛБАРЫН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН СИСТЕМ, СҮЛЖЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ДОТООД СҮЛЖЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Ц.ЛХАГВАДОРЖИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
Стратегийн зорилт: Салбарын статистик, суурь судалгааг боловсруулах, хөгжүүлэх, мэдээлэл, технологийг нэвтрүүлэх, цахим шилжилтийг идэвхижүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх							
1.1.47	Салбарын цахим арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 03 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /цахимжуулах/-г батлуулсан	Цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөөний Хэрэгжилт 15 хувьд хүрсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 4.2.2.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын салбарын цахим шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөө”-г харьяа байгууллагуудаас саналыг авч нэгтгэн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 05 дугаар сарын 22-ний өдрийн 117 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Энэхүү төлөвлөгөөгөөр 2025-2028 онд 14 зорилтын 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн	2025.01.01 - 2025.12.31	100

					<p>03/2243 тоот албан бичгийг харъяа байгууллагуудад хүргүүлсэн. Тус төлөвлөгөөний 1.1-т туссан тусгай зөвшөөрлийн цахим системийг "license.mn"-д холбох, мэдээлэл солилцох урсгалыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Санхүүгийн мэдээллийн технологийн төв"-тэй Тусгай зөвшөөрлийн нэгдсэн систем "license.mn"-д шинээр хөгжүүлэлт хийлгэн барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг тус системээр олгож байна. Аж ахуй нэгж байгууллагын мэдээлэл болон инженер техникийн ажилтнуудын мэдээллийг mcis.gov.mn системээс API сервис холболтоор хүлээн авч боловсруулалт хийгдсэний дараа буцаан дамжуулах тохиргоо хийгдсэн. Төлөвлөгөөний 1.3-т заасан "Барилгын материалын мэдээллийн нэгдсэн сангийн цахим системийг хөгжүүлэх" ажлын санхүүжилтийг "Барилга, байгууламжийн норм, нормативын сан"-ийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тусгуулан, барилгын материалын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-н мэдээллийг дэлгэрэнгүй харах, барилгын материалын сорилт шинжилгээний лабораториос хариу авах, технологийн заавар хянуулах, батлуулах, тохирлын гэрчилгээний хүсэлт илгээх зэрэг барилгын материалтай холбоотой үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, https://materials.mcis.gov.mn/ системийг</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>ашиглалтад оруулсан. Мөн төлөвлөгөөний 1.4-т туссан барилгын салбарт BIM нэвтрүүлэх бэлтгэл арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн А/102 дугаар тушаалаар салбарт “Барилгын мэдээлэлтэй загварчлал BIM”-ийг нэвтрүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж “BIM”-г үе шаттай нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна. 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Их Британи, Умард Ирландийн Нэгдсэн Вант Улсын Элчин сайдын яамны төлөөлөл болон тус улсын төр, хувийн байгууллагатай хамтарсан “Дижитал бүтээн байгуулалт” сэдэвт форум зохион байгуулж, төлөвлөлт, зураг төсөл, үйлдвэрлэл, барилга угсралт, хяналт, ашиглалт хүртэлх бүх үе шатыг өгөгдөлд суурилсан шийдлээр уялдуулах талаар холбогдох ААНБ, иргэдэд мэдээлэл хүргүүлэн ажилласан. Төлөвлөгөөний 1.6 “Хот байгуулалтын кадастрын системд 21 аймгийн хэмжээнд барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламж бүртгэх, нөхөн бүрдүүлэлт хийх”, “21 аймгийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт хот байгуулалтын кадастрын системд тогтмол тоон мэдээллийг бүрдүүлэх сургалтад хамруулах, арга зүйгээр хангах” ажлын хүрээнд системийн нэмэлт хөгжүүлэлтийг системийг хариуцаж байгаа ГЗБГЗЗЕГазарт улсын төсвийн хөрөнгөөр хийж дуусгуулан, 21 аймгийн холбогдох мэргэжилтнүүдэд ГЗБГЗЗЕГазартай хамтран яаман дээр</p>		
--	--	--	--	--	--	--	--

	<p>нэгдсэн мэдээллийн сангийн цахим системийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавих</p>	<p>хэвийн үйл ажиллагаа</p>	<p>/www.mcis.gov.mn/-ээр дамжуулан 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн байдлаар нийт 13402 хүсэлтийг хүлээн авч, Барилгын үйл ажиллагаа эрхлэх 2865, БМУ чиглэлээр 95, Хот байгуулалтын чиглэлээр 3 тусгай зөвшөөрөл олгоод байна.</p>	<p>тогтвортой, хэвийн, аюулгүй үйл ажиллагаанд шаардлагатай нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийгдсэн байна. Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.</p>	<p>байдлаар нийт 5636 хүсэлтийг хүлээн авч, 2253 ААНБ-д тусгай зөвшөөрөл олгоод байна. Уг системийн үндсэн сервер “Үндэсний дата төв” УТҮГ-д байрлаж, Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем, Танилт нэвтрэлтийн ДАН системүүдтэй холбогдон ажиллаж байна. Тусгай зөвшөөрлийн нэгдсэн системийг Зөвшөөрлийн хуультай уялдуулан нэмэлт сайжруулалт хийх ажлын хүрээнд барилгын тусгай зөвшөөрлийг Барилгын нэгдсэн мэдээллийн систем /www.mcis.gov.mn/-ээр олгодог байсанг Тусгай зөвшөөрлийн нэгдсэн систем “license.mn”-д шинээр хөгжүүлэлт хийлгэн барилгын салбарын тусгай зөвшөөрлийг олгохоор болсон. Аж ахуй нэгж байгууллагын мэдээлэл болон Инженер техникийн ажилтаны мэдээллийг mcis.gov.mn системээс API сервис холболтоор хүлээн авч боловсруулалт хийгдсэний дараа буцаан дамжуулах тохиргоо хийгдсэн. Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл, Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл, Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлүүдийг тус системээр олгож байна. Мэдээллийн сангийн цахим системд хандах үндсэн хэрэглэгчийн эрх олгох тухай Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/04, 02 дугаар сарын 19-ны өдрийн А/24, 05 дугаар сарын 21-ны өдрийн А/92 дугаар тушаалуудыг батлуулан ХББОСЯ-ны тусгайлсан чиг</p>		
--	---	-----------------------------	--	--	--	--	--

					үүрэг бүхий албан хаагч нар болон Монголын үндэсний ассоциаци НҮТББ-н албан хаагч нарт эрх олгосон. Тус системийн холболт тохиргоо хийгдэн ашиглалтад оруулснаас хойш нийт Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл 88, Өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл 14, Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл 413 тус тус олгоод байна.		
1.1.49	Яамны цахим хуудсыг сайжруулах, нэмэлт хөгжүүлэлт хийх, нээлттэй мэдээллийг цахим хуудсанд байршуулж нийтлэх, шинэчлэх ажлыг зохион байгуулах	Цахим системийн хэвийн үйл ажиллагаа	Цахим хуудасны мэдээллийн баяжилтыг хийх, мэдээллийн ил тод байдал, хэвийн үйл ажиллагааг хангасан байна.	Цахим системийн тогтвортой, хэвийн, аюулгүй үйл ажиллагаанд шаардлагатай нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалт хийгдсэн байна. Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9 дүгээр хавсралт "Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт"-ийн дагуу яамны 2024 оны ил тод байдлын тайланг нэгтгэн гаргаж 2025 оны 01 дүгээр сард ХШҮДАГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналтшинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний цахим сан /new.unelgee.gov.mn/-д баталгаажуулж,	2025.01.01 - 2025.12.31	100

					<p>2025.01.02-ны өдрийн 03/03 дугаар бичгээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлсэн. ЦХИХХЯ-наас яамдын нээлттэй мэдээллийг ил тод болгож, байршуулсан тайланд үнэлгээ хийж, үнэлгээг шинэчлэгдсэн шилэн систем /shilen.gov.mn/-д улирал бүр тайланг илгээж 87 шалгуур үзүүлэлтийг тус бүр ил тод нээлттэй байршуулсан. Цахим хуудасны лого-г шинэчилж, стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор газар хэлтсүүдийн мэдээллүүдийг шинэчилсэн. “Дулаан байшин” нээлттэй өдөрлөгт зориулж амины орон сууцны мэдээллийн төвийг бүрэн виртуал хэлбэрт шилжүүлсэн. Мөн эрчим хүчний хэмнэлттэй ногоон амины орон сууцуудыг виртуал хэлбэрт оруулж иргэдэд цахим хуудсаар дамжуулан виртуал орчинд өөрсдөө очиж үзэн мэдээ, мэдээлэл авах, 40 гаруй нэг маягийн зураг төслийг үнэгүй ашиглах, паспортжуулсан барилгын мэдээллийг ил тод болгож дүүрэг тус бүрээр ялган харах зэрэг нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг бүрэн ханган ажилласан. Цахим хуудасны нүүр хэсэгт шинээр салбарын системүүд, тусгай зөвшөөрлийн мэдээллүүд, хууль, эрх зүйн мэдээллийг шинээр үүсгэж байршуулсан. Цахим хуудасны мэдээллийн аюулгүй байдал, найдвартай байдлыг хангаж, яамны албан хаагчдаас ирүүлсэн мэдээ, мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулж, цэс нэмэх, линк холбох,</p>	
--	--	--	--	--	--	--

холбогдох мэдээ мэдээллийг бүрэн оруулж нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг бүрэн ханган ажилласан.

Зорилт 2. Салбарын өгөгдлийн сан, мэдээллийн системийн уялдаа холбоог нэгдсэн удирдлагаар хангах, харилцан мэдээлэл солилцох техникийн шийдэл болон технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

1.1.50	Барилгын материалын мэдээллийн нэгдсэн сангийн системийг хөгжүүлэх ажлыг холбогдох нэгж, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	Цахимжуулалтын хувь	Нормчлолын сан	Барилгын материалын мэдээллийн санг цахимжуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байна.	Барилгын материалын мэдээллийн нэгдсэн сангийн системийг хөгжүүлэх ажлын санхүүжилтийг “Барилга, байгууламжийн норм, нормативын сан”-ийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тусгуулан, барилгын материалын нэгдсэн мэдээллийн сангийн цахим систем /materials.mcis.gov.mn/-ийг хөгжүүлэх ажлын хүрээнд барилгын материалын тусгай зөвшөөрөлтэй ААНБ-н мэдээллийг дэлгэрэнгүй харах, барилгын материалын сорилт шинжилгээний лаборториос хариу авах, технологийн заавар хянуулах, батлуулах, тохирлын гэрчилгээний хүсэлт илгээх зэрэг барилгын материалын материалын лабораторийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулсан.	2025.01.01 - 2025.12.31	100
1.1.51	Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим системийг нэвтрүүлэх ажлыг холбогдох нэгж, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	Цахимжуулалтын хөгжүүлэлт, нэвтрүүлэлт	“Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг” ОУБ-ын “Барилгын салбарын эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх нь төсөл”-ийн санхүүжилтээр “Барилгын	Системийн тогтвортой хэвийн үйл ажиллагааг хангах ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байна.	Хүлэмжийн хийн тооллогын цахим систем /ghgconstruction.gov.mn/-ийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төв, Үндэсний дата төв УТҮГ”-уудтай хамтран Хүлэмжийн хийн тооллогын системийн “10.2.109.11 – 103.48.116.165 NAT хаяг”-ийн серверээс “auth”, “bash history” зэрэг файлуудыг гарган авч, кибер аюулгүй байдлыг хангах ажлыг хамтран хэрэгжүүлж, нэвтрэх нууц үгийг шинэчилж, тус систем дотор үүссэн халдлагын чанартай хортой кодуудыг	2025.01.01 - 2025.12.31	90

			салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим систем"-ийг сайжруулж, улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн.		цэвэрлэн кибер халдлагаас урьдчилан сэргийлж гадаад хаяг, хандах эрхийн портуудыг хаалган хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан. 2025 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт (ҮТХН буюу NDC)-ыг хэрэгжүүлэх зорилгоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй "Эн Ди Си" төслийн хүрээнд Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим системийн үйл ажиллагааг сайжруулах, хөтлөх, бүрдүүлэх чиглэлээр салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулахад хамтарч ажиллан, Барилгын салбарын мэдээллийн /pmis/ систем болон хүлэмжийн хийн тооллогын цахим системийн уялдаа, үйл ажиллагааны талаарх танилцуулга сургалт хийсэн.		
1.1.52	Орон сууцны бүртгэл, мэдээллийн нэгдсэн портал, гар утасны аппликейшн хөгжүүлж, нэвтрүүлэх ажлыг холбогдох нэгж, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	Орон сууцны мэдээллийн сангийн WEBGIS, түрээслээд өмчлөх болон түрээсийн орон сууцны модуль	Орон сууцны бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх	Системийн техникийн баримт бичиг, ажлын даалгавар боловсруулж, холбогдох байгууллагууд аас санал авч, батлуулах. Системийн техникийн баримт бичгийн дагуу	Төрөөс иргэдийг орлогод нийцсэн орон сууцаар хангах бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд "Орон сууцны зах зээлийн борлуулалт, үнэ, нийлүүлэлт, эрэлтийн мэдээлэл" төсөл хөтөлбөр, түрээсийн орон сууц, Ипотекийн 6 хувийн орон сууцны зээлийн хүсэлт, сонгон шалгаруулалт, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний мэдээлэл" зэргийг нэгтгэн удирдах, хянах, шинжлэх боломжийг бүрдүүлж, орон сууцны эрэлт, нийлүүлэлтэд тулгуурлан, иргэдийн худалдан авах чадварыг дэмжих, шийдвэр гаргалтад шаардлагатай зах зээл дээрх орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн	2025.01.01 - 2025.12.31	100

				холбогдох төрийн байгууллагуудт ай мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх, хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан байна.	статистик, тоон мэдээллийг бодит агшинд бүрдүүлэх цахим систем хөгжүүлэх техникийн баримт бичгийг боловсруулж “Төрийн орон сууц корпораци” ТӨХХК-д хүргүүлсэн. Мөн төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан систем хөгжүүлэх компанийг сонгон шалгаруулах ажиллагаанд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэн ажиллаж байна.		
1.1.53	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн системийн мэдээллийн баазыг холбогдох нэгж, байгууллагуудтай хамтран зохион байгуулж, бүрдүүлэх.	Цахим системийн нэвтрүүлэлт	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн системийг холбогдох нэгж, байгууллагуудтай хамтран хэрэглээнд нэвтрүүлсэн.	Цахим системийг нийслэлийн хот байгуулалтын мэдээллийн сантай холбох, сайжруулах ажлыг холбогдох нэгж, байгууллагуудт ай хамтран зохион байгуулж, дэмжлэг үзүүлсэн байна.	Хот байгуулалтын кадастрын цахим системийн нэмэлт хөгжүүлэлтэд Барилгын тухай хуулийн 35.1.4-т “тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах;” гэж заасны дагуу Улсын хэмжээнд паспортжуулалт хийсэн барилга байгууламжийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, мөн ерөнхий архитектуруудын тайлан, жижүүр хөтлөлтийн тайланг системээр авах саналыг хүргүүлж, “Хот байгуулалтын кадастрын цахим системийн хөгжүүлэлт хийх үйлчилгээн”-ний 2025/76 дугаар гэрээг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр “Эрхэт-Инноваци” ХХК-тай байгуулсан. Гэрээт ажлын хүрээнд Зургийн давхаргын үзүүлэлт, өгөгдөл мэдээллийн давхардлыг арилгах, Гүйцэтгэлийн зураг оруулахад хавсралт дотор нь нэг удаа гүйцэтгэгч, захиалагчийн мэдээлэл оруулдаг болох, Шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийг нэгдсэн байдлаар оруулах, акт гаргах боломжтой болгох, Инженерийн	2025.01.01 - 2025.12.31	100

				<p>шугам сүлжээний зургийн даалгаврын хүчин чадал дээр цахилгааны хэмжих нэгж байхгүй байгааг оруулах, Зургийн даалгавар хэвлэхэд цахилгаан, холбооны даалгаврын сонголт гарч ирэхгүй байгааг засварлах, Барилгын зориулалтаас хамаарч маягт өөрчлөгддөг болгох, Зургийн давхаргад өгөгдөл оруулан хадгалахаас өмнө зургийг хаана орж байгааг харах байдлаар дэлгэцэнд харах боломжтой болгох, Хавсралт файлыг *.гаг өргөтгөлөөр оруулж болдог болгох, Өгөгдлийн үзүүлэлтийг олноор нь сонгож нэгээс нөгөөд хуулах боломжтой болгох, Барилга, байгууламжийн өгөгдөл мэдээллээс боловсруулалт анализ хийж нийгмийн дэд бүтэц болох сургууль, цэцэрлэг, соёл, спорт, худалдаа үйлчилгээний барилгуудыг зориулалтаар нь өнгөөр ялган харуулдаг болгох, Зургийн давхарга дээр барилгыг зориулалтаар нь ялгаж харах боломжийг бүрдүүлэх, Барилга, инженерийн шугам сүлжээний зөвшөөрлийн хүсэлт шийдвэрлэх үед барилга, трассын лайн тус бүрд зураг төсөл зохиогч, захиалагч, гүйцэтгэгчийн мэдээллийг олон талбарт дахин давтан бичдэгийг болиулах, Барилга барих хүсэлт илгээхэд нэгж талбар болон барилгын талбайн хэмжээг тооцоолон 60x40 харьцааг бариагүй тохиолдолд хүсэлт илгээх боломжгүй болгох, Мэргэжилтнээс хүсэлт буцаахад иргэн, аан засаж оруулах, мэдээлэл нэмх, хасах боломжтой болгох, Нэвтэрч ороогүй хүсэлтийг өнгөөр ялгах зэрэг ажлууд хийгдсэн. Хот байгуулалтын</p>	
--	--	--	--	---	--

					кадастрын системд 21 аймгийн хэмжээнд барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламжийг бүртгэх, нөхөн бүрдүүлэлт хийх чиглэлээр удирдамж гарган арга зүйгээр хангах, төлөвлөгөө боловсруулж батлуулах төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		
1.1.54	Салбарын мэдээллийн сан, цахим системийн уялдаа холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, системийн нэгтгэлийг хөгжүүлэх бодлого, удирдамжаар хангах	Төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох үйлчилгээ, дундын мэдээллийн сан	Салбарын мэдээллийн сан, цахим системүүдийг нийтийн мэдээллийн /ХУР/, танилт, нэвтрэлийн систем /ДАН/, Төрийн мэдээллийн нэгдсэн системд холбох, веб сервисүүдийн ашиглалтыг нэмэгдүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах ажлыг зохион байгуулсан	“Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны мэдээллийн аюулгүй байдлыг хангах 2025 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан байна. Төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн эмзэг, сул байдлыг илрүүлэх, үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, тоног	Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/66 тушаалаар баталсан “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам, Мэдээллийн систем ашиглах журам, Мэдээллийн системийн администраторын журам”-д заасныг үндэслэн “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны мэдээллийн аюулгүй байдлыг хангах 2025 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөнд туссан Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн баталгаажуулалт, хөндлөнгийн хяналтын тогтолцоо бий болгож эмзэг байдлыг бууруулах ажлын хүрээнд Албан ёсны лиценз бүхий программ хангамжуудыг худалдан авч техник, хэрэгслийн мэдээллийн аюулгүй байдлыг ханган эрсдэлийг бууруулсан. Төрийн нэгдмэл сангийн сүлжээний тоног төхөөрөмжүүдийг шинэчлэн сайжруулж хэвийн, найдвартай аюулгүй үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн Төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн эмзэг, сул байдлыг илрүүлэх, үнэлгээ хийлгэх ажлын хүрээнд ТЕГ-н Мэдээллийн	2025.01.01 - 2025.12.31	100

			<p>төхөөрөмжийг сайжруулсан байна.</p>	<p>аюулгүй байдлын газарт хүсэлт гаргаж “Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ”-г 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 27-ны өдрийн хооронд хийлгүүлж, заавар зөвлөмж хүргүүлэн авсан. 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газартай хамтран ХББОСЯ-ны эрсдэлийн үнэлгээний тайланг танилцуулж, “Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, анхаарах зарим асуудал”-н талаарх сургалтыг нийт албан хаагчдад орж, заавар зөвлөмжийг өгч ажилласан.</p> <p>Яамны дотоод сүлжээ, интернэтэд суурилсан харилцаа, программ хангамжийн Рүүтэр төхөөрөмжийн Галт ханын тохиргоонд аюулгүй байдлыг сайжруулах тохиргоо хийн, хориглосон веб сайтуудыг блоклосон. Мөн кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний төвөөс ирүүлсэн Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд танай байгууллагаас хортой кодын С2 сервер болох 146.66.215.206 хаяг руу хандалт тогтоож байгааг илрүүлсэн мэдэгдэл ирсний дагуу яамны бүх компьютер серверийн төхөөрөмжүүдийн хортой кодыг устган цэвэрлэж аюулгүй байдлыг ханган хэвийн үйл ажиллагаанд оруулан ажилласан. Салбарын мэдээллийн сан, цахим системийн уялдаа холбоо, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, системийн нэгтгэлийг хөгжүүлэх бодлого, удирдамжаар хангах ажлын хүрээнд Яамны цахим хуудсанд</p>	
--	--	--	--	---	--

					салбарт нийт ашиглагддаг системүүд, тусгай зөвшөөрлийн мэдээллүүд, хууль, эрх зүйн мэдээллүүдийн линк /URL/ хаягийг холбож нэг хуудаснаас иргэд болон ААНБ-уудад салбарын бүхий л мэдээ, мэдээлэлүүдийг ил тод нээлттэй харуулах боломжийг бүрдүүлэн ажилласан. Мөн бүх шатны төрийн захиргааны байгууллагуудад зориулсан төсвийн нэгдсэн систем "Opengov"-ийг салбарын хэмжээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн А/120 дугаар тушаалаар байгуулж "Даталанд" ХХК-тай хамтран "Үндэсний дата төв" УТҮГ-т Cloud сервер үүсгүүлж программ хангамжийг бүрэн суулган системийг ажиллагаанд оруулж Сангийн яамны Төрийн сангийн цахим хуулга систем /и-хуулга/ болон /Fiscal B/ системүүдтэй интеграци хийж мэдээлэл солилцох боломжоор ханган /API/ сервис холболт хийн хэвийн үйл ажиллагаанд оруулж бүрэн нэвтрүүлэх боломжийг ханган ажилласан.		
Зорилт 3. Мэдээллийн сан, сүлжээний аюулгүй байдал, техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангана.							
1.1.55	Яамны техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах	Техник, тоног төрөөхөмж, программ хангамжийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагаа	Сүлжээ, техник, тоног төхөөрөмж, программ хангамж боловсронгуй болж, найдвартай, хэвийн тасралтгүй	Сервер, сүлжээний тоног төхөөрөмж, компьютер тоног төхөөрөмжийг шинэчлэх, программ хангамжийн ашиглалтыг сайжруулах,	ХББОСЯ-ны барилгын их засварын ажлын хүрээнд 3 болон 4 давхрын коридорын сүлжээг шинэчлэн татаж, ашиглагдахгүй сүлжээний кабел, холбооны кабел, шилэн кабелуудыг тасдан авч, ерөө тус бүрт UTP кабел шинээр татаж, сүлжээнд холбох, сүлжээг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн шинээр цаг бүртгэлийг төхөөрөмж суурилуулж албан хаагчдыг бүртгэл, холболт тохиргоог хийн ажилласан. Албан хаагчдын компьютер,	2025.01.01 - 2025.12.31	100

			<p>үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд Компьютер-31 Нотебүүк-6 Сүлжээний принтер-2 Microsoft Office 365 программын лиценз 75, Хортой код эсэргүүцэх программ хангамж /Kaspersky antivirus/ - 100 ширхэгийг худалдан авч, тохируулан хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангасан</p>	<p>техник, тоног төрөөхөмж, программ хангамжийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг ханган ажилласан байна</p>	<p>тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах ажлын хүрээнд 2025 эхний хасаг жилд нийт 15 албан хаагчдын компьютеруудыг шинээр сольж, 7 албан хаагчдын компьютерт нэмэлтээр ram, hard зэрэг бусад тоног төхөөрөмж суурилуулж, сайжруулан холболт тохиргоог хийн программ хангамжуудыг суулган хэвийн үйл ажиллагаанд оруулан ажилласан. Мөн “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-с төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засварын ажил хийгдэж байгаатай холбогдуулан Яамны сүлжээний рүүтер төхөөрөмж нь унтарч асахдаа автоматаар хаяг тараах, зарим хаяг нь өөрчлөгдөж болохгүй төхөөрөмжид тогтмол хаяг өгөх тохиргоо хийж, байгууллагын компьютерийн дотоод болон гадаад сүлжээний аюулгүй байдал, техник, тоног төхөөрөмж, хэрэглээний программ хангамжийн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг ханган ажилласан. Хортой код эсэргүүцэх программ хангамж /Kaspersky antivirus/-ийн лицензийн хугацаа дууссан тул 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 2025/338 дугаар “Лиценз худалдан авах гэрээ”-г байгуулж Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж гэрээнд заасан төлбөр нэхэмжлэхийг Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.</p>		
1.1.56	Байгууллагын албан хаагчдын мэдээлэл, технологийн мэдлэгийг	Цахим хэлбэрт шилжүүлсэн үйл ажиллагааны тоо;	Төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх	Байгууллагын үйл ажиллагаанд цахим соёл нэвтрүүлж,	Яамны хэмжээнд видео хурлын ZOOM, Teams программ хангамжуудыг ашиглан 2025 оны 1-р сараас 12-р сар хүртэл 900 гаруй цахим уулзалт болон хурал зохион байгуулах ажлыг тухай бүр хэрэглэгчдэд эрхийг нээж өгөн мөн	2025.01.01 - 2025.12.31	100


					үргэлжлүүлэн сунгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.		
1.1.57	Байгууллагын дотоод удирдлагын систем (ERP), цаг бүртгэлийн төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах	Дотоод удирдлагын системийн хэвийн, тасралтгүй, найдвартай үйл ажиллагаа	2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Байгууллагын дотоод удирдлагын систем (ERP)-ийг яамны дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.	Байгууллагын дотоод удирдлагын системийн тасралтгүй, найдвартай үйл ажиллагаа хангагдсан байна. Тус системээр дамжуулан Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төсөл боловсруулан санал авах болон дотоод албан бичиг илгээх боломжийг бүрдүүлж өгөх, нийт албан хаагчдад системийн ашиглалтын сургалт орсон байна.	Байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем ERP системээр дамжуулж цахимаар албан бичиг боловсруулах ажлын хүрээнд нийт албан хаагчдыг чадавхжуулах, тогтмол заавар зөвлөмж сургалт орж, яамны нийт албан бичгийн 80% нь бүрэн цахимжсан байна. Мөн ХББОСЯ-ны Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийг цахимаар боловсруулах боломжтой болгож 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр нийт албан хаагчдад сургалт орж, заавар зөвлөмж өгч ажилласан. Сайд, ТНБД-н тушаалын саналын хуудсыг цахимаар тойруулах боломжтой болгож нийт тушаалын 80%-г цахимаар боловсруулж байна. Цаг бүртгэлийн төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд шинэчлэн батлагдсан хөдөлмөрийн дотоод журмын дагуу цаг бүртгэлийг уян хатан болгож 08-09 цагийн хооронд бүртгүүлэх боломжтой болгож, 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн Б/133 “Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Төрийн нарийн бичгийн даргын тушаалын дагуу системийн тохиргоонуудыг хийсэн. Мөн бүтэц зохион байгуулалтын өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн “Б/118” тушаалын дагуу бүтэц, зохион байгуулалт, нэгж, албан тушаалын өөрчлөлт, сэлгэн, шилжин ажиллах албан хаагч тус бүрийн бүртгэл, албан	2025.01.01 - 2025.12.31	100

1.	Арга хэмжээ 1. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах сургалт, хөтөлбөрт хамрагдах.	Хариуцсан ажлын чиглэлээр зохион байгуулагдах дотоодын сургалт, семинарт хамрагдсан байна.	Хариуцсан ажлын чиглэлээр зохион байгуулагдах дотоодын сургалт, семинарт хамрагдсан байна.	IPv6 Deployment Workshop Mongolia" сургалтад хамрагдах.	2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр "System center" ХХК-с зохион байгуулсан "Network traffic monitoring & analysis" сургалтад Cisco Webex онлайнаар хамрагдсан.	2025.01.01-2025.12.31	100
2.	Арга хэмжээ 2. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах сургалт, хөтөлбөрт хамрагдах.	Хариуцсан ажлын чиглэлээр зохион байгуулагдах дотоодын сургалт, семинарт хамрагдсан байна.	Хариуцсан ажлын чиглэлээр зохион байгуулагдах дотоодын сургалт, семинарт хамрагдсан байна.	Мэдээллийн аюулгүй байдлын сургалтад хамрагдах.	Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтыг үндэслэн Кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ авах ажлын хүрээнд Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх төвүүд хамтран 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр "Кибер тусгаар тогтнол" сургалт, арга хэмжээнд хамрагдсан.	2025.01.01-2025.12.31	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын удирдлагын мэдээллийн нэгдсэн систем, сүлжээний аюулгүй байдал, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн

(Албан тушаал)

Ц.Лхагвадорж /  /

(Нэр, гарын үсэг)

2025 12 08

(Огноо)